


Тооны нэр, баримт нотолгоо, жишээ ашиглан танилцуулгыг тоочин бичих

VII анги



Хичээлийн зорилго


- Танилцуулгын төрөл, сэдэв сонгох
- Танилцуулга бичих алхмуудыг мэдэж авах
- Төлөвлөх





Танилцуулга бичихдээ дараах алхмуудыг анхаарах

- Хэний, юуны талаар танилцуулахаа тогтох
- Оновчтой, сонирхолтой, анхаарал татахаар гарчиг өгөх
- Эхлэл, гол, төгсгөл хэсэгтээ юуны тухай бичихээ төлөвлөх
- Бичих зүйлийнхээ ололттой, дэвшилттэй, бахархалтай талаас бичих
- Төлөвлөгөөний дагуу цуглуулсан хэрэглэгдэхүүнээ нэгтгэн , хэсгүүдийг уялдаатай бичих
- Өгүүлбэрүүдийг товч тодорхой тоочин бичих
- Уншигч , сонсогчид шинэ мэдээ, мэдээлэл авахаар байх
- Уншигч ,сонсогчдод бахархан дуурайх сэтгэгдэл төрүүлэх, тэднийг итгүүлэх, үнэмшүүлэх арга хэрэглүүр ашиглах
- Танилцуулгаа сайжруулан бичих




Танилцуулгын бүтэц

Эхлэл	■ Танилцуулах зүйлийн тухай товч бичнэ.	
Гол	... Өнгөрсөн одоо , ирээдүйн зорилго, үйл ажиллагааны онцлог болон ном зохиол, уран бүтээл, бараа бүтээгдэхүүний шинж чанарыг таниулах, мэдээлэх, сурталчлах • Эхлэл, гол, төгсгөл хэсгүүд нь холбоотой. • Тооны нэр хэрэглэсэн \ тоо баримт ашиглах\ • Тоочсон зэрэгцсэн өгүүлбэрийн найруулга голлосон байна. • Үгийг шууд утгаар хэрэглэсэн байна. • Бодит баримтад тулгуурласан байна.	• Догол мөр бүр өмнөх ба дараагийн догол мөртэйгээ холбогдсон уу? Яаж? • Догол мөр бүр нь нэг гол санааг агуулсан уу?
Төгсгөл	• Танилцуулж буй зүйлийн үр өгөөж, ач тусыг дүгнэж бичнэ.	

Танилцуулгыг үнэлэх шалгуур

Шалгуур	Тийм	Үгүй
1. Танилцуулж буй зүйлийнхээ сонин содон шинжийг дүрсэлж чадсан уу?		
2. Эхийн хэсгүүдийг догол мөрөөр заагласан уу?		
3. Эхийн хэсгүүд уялдаа холбоотой юу?		
4. Тоо баримт ашигласан уу?		
5. Шинэ мэдээ, мэдээлэл агуулсан уу? Эхийн аль хэсэгт байна вэ?		
6. Бичиж буй зүйлийнхээ ололт, амжилттай бахархалтай талыг тодорхой илэрхийлж чадсан уу?		
7. Холбоо хамааралгүй зүйлийг бичсэн хэсэг байна уу?		
8. Уншигч, сонсогчийг итгүүлэх, үнэмшүүлэх тэдэнд хүсэл төрүүлэх ямар нэг арга хэрэглэсэн үү? Тийм үг, өгүүлбэр байна уу?		
9. Найруулгын болоод зөв бичих дүрмийн алдаа байна уу?		
10. Сонирхол татах гарчиг өгч чадсан уу?		
11. Гол төлөв тоочсон өгүүлбэрээр бичсэн үү?		
12. Үгийг шууд утгаар хэрэглэсэн үү?		





Сонирхолтой сэдвээр танилцуулга бичье

Өөрийн сонгон суралцдаг клуб,
секц дугуйлангийн талаар

- Шатар , даам, бадминтон,
хөгжим, номын клуб


- Сургуулийн танилцуулга
- Сурагчдын зөвлөлийн
танилцуулга
- Музейн танилцуулга
- Номын танилцуулга



Дүрслэх урлаг ,технологийн
хичээлээр хийж сурсан
зурсан зураг, нэхмэл,
наамал , шүр сувдаар хэлхэж
хийсэн бүтээгдэхүүний
танилцуулга

- Аяллын танилцуулга
- Бүтээлийн үзэсгэлэнгийн
танилцуулга
- Ангийн хамт олны
танилцуулга

Танилцуулга унших



“Улаан тоорцогт” номын танилцуулга

Энэтхэгийн хүүхдийн зохиолч эмэгтэй Манарофа Жафа нь дэлхийн хүүхдийн зургийн уралдааныг зохион байгуулагч, олон нийтийн зүтгэлтэн юм. Тэрээр зураачдын холбооны ерөнхий нарийн бичгийн дарга багаад хүүхдийг номоор хүмүүжүүлэх талаар ихээхэн ажил хийжээ. Түүний зохиосон үлгэрүүд хүүхдийг амьдрах ухаанд сургах санаа агуулдаг бөгөөд хамгийн алдартай бүтээл нь “Улаан тоорцогт” ном юм.

“Улаан тоорцогт” номд ээжтэйгээ амьдардаг. Типү гэдэг хүүгийн тухай өгүүлнэ. Ээжийнхээ оёж өгсөн улаан тоорцгийг үргэлж өмсөж явдаг тул хүмүүс түүнийг “Улаан тоорцогт” гэж дууддаг байлаа. Ээжийнх нь бие өвдөж, өдөр өдрөөр муудаж, буйг анзаарсан Улаан тоорцогт нэг өдөр хүнс цуглуулахаар зах дээр явж байгаад хийсэн цаасан онгоцоо зарж орхижээ. Ингээд ажил хийж, ухаан зарвал мөнгө олж болохыг ойлгосон Типү эрдэнэ шишийн үр худалдан авч, хуурч болгоод зарж эхэлжээ. Цаашид уйгагүй ажилласаар “Улаан тоорцогтын эрдэнэ шиш” гэдэг дэлгүүртэй болж, аз жаргалтай амьдарч буйгаар үлгэр төгсөнө.

“Улаан тоорцогт” хэмээх энэ үлгэр нь хүүхдэд зах зээлийн нийгэмд амьдрах арга ухаан, эдийн засгийн наад захын ойлголтыг өгч байгаагаараа цаг үеэ олсон бүтээл болсон байна.

Эхлэл Зохиогчийн танилцуулга

- Хүүхдийн зохиол
- Злхион байгуулагч
- Олон нийтийн зүтгэлтэн
- Зураачдын холбоо
- Ерөнхий нарийн бичгийн дарга


Гол хэсэг Номын гол агуулга

- Типү хүү
- Улаан тооцогт
- Цаасан онгоц
- Эрдэнэ шиш
- Дэлгүүр
- Аз жаргал

Төгсгөл Номын ач тус

- Зах зээлийн нийгэм
- Эдийн засгийн ойлголт өгсөн бүтээл

Скаутын танилцуулга



Скаутын хөдөлгөөнийг анх 1907 онд Английн цэргийн нэрт жанжин Роберт Баден Пауэл үндэслэжээ. Эдүгээ 100 гаруй жилийн турш энэхүү хөдөлгөөн дэлхийн янз бүрийн улс үндэстэн, бүс нутагт үйл ажиллагаагаа явуулж байна.

Энэхүү хөдөлгөөнийг үндэслэгч нь аливаа хүний гарал үүсэл, арьсны өнгө, шашин шүтлэгээс үл хамааран хүүхэд, залуучуудыг хүмүүжүүлэх зорилготойгоор анх байгуулсан байна. Тиймээс энэ нь улс төрийн бус, нийтэд нээлттэй, сайн дурын хөдөлгөөн юм.

Скаутын хөдөлгөөний гол зорилго нь хүүхэд залуучуудыг оюун ухаан, нийгэм сэтгэл санааны чадамжаа бүрэн дүүрэн дээшлүүлэх, хувь хүн болон өсөж хөгжихөд нь дэмжлэг үзүүлэхэд оршино.

Get Involved

- List opportunities for parents to become involved in volunteer programs, advisory councils, and the PTA.
- Provide sign-up sheets for parents who are interested in helping to plan parties or special projects for your class.



Анхаарал тавьсанд
баярлалаа.